**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,**
**ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН**
**ТОГТООЛ**

2018 оны 9 сарын 05 өдөр Дугаар 379 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө худалдан авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад суугаа Элчин Сайдын яамны албан ажлын хэрэгцээнд зориулан батлагдсан төсөвт багтаан хавсралтад заасан суудлын автомашин худалдан авахыг зөвшөөрсүгэй.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд холбогдох хууль тогтоомжийн дагуу тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГАВАА

0002700

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 09 дүгээр сарын ....05.... -ны өдрийн
....379.....дугаар тогтоолын хавсралт

**Монгол Улсаас Бүгд Найрамдах Арчилсан Солонгос Ард Улс ад суугаа элчин Сайдын яаманд худалдан авах автомашины техникийн үзүүлэлт**

| Д/д | Автомашины техникийн үзүүлэлт | Хэмжих нэгж | Тоо ширхэг |
|---|---|---|---|
| 1 | Элчин Сайдын яаманд албан ажлын хэрэгцээнд суудлын автомашин /суудлын тоо 5, 2500-4000 сс хөдөлгүүрийн багтаамжтай/ | ш | 2 |
| | **Нийт дүн** | | **2** |